

2021.1.1- нээс ГАДААДЫН ИРГЭДИЙН ШИНЭ ҮҮРЭГ: ДАСАН ЗОХИЦОХ –ИНТЕГРАЦИЙН КУРС

2021 оны 1-р сарын 1-ээс хойш БНЧУЛсад удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл олгогдсон гадаадын иргэн бүр, мөн энэ өдрөөс хойш тухайн нутаг дэвсгэрт урьд нь оршин суух нөхцөлгүйгээр байнгын оршин суух зөвшөөрөл олгогдсон гадаадын иргэн бүр **оршин суух зөвшөөрлийн үнэмлэх хүлээн авсан өдрөөс хойш нэг жилийн дотор** дасан зохицох интеграцийн курсыг **дүүргэсэн байх үүрэгтэй.**


ДАСАН ЗОХИЦОХ-ИНТЕГРАЦИЛАХ КУРС ГЭЖ ЮУ В? Дасан зохицох-интеграцийн курс нь гадаадын иргэд БНЧУЛсад оршин суухаас үүсэх эрх, үүрэг, Чех улсын үндсэн утга үнэлэмж, орон нутгийн нөхцөл байдлын онцлог, Чех улсад зонхилдог соёлын зан заншилтай танилцах курс юм. Түүнчлэн курст оролцогсдод гадаадын иргэдэд үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх төрийн ба бусад байгууллагуудын талаар мэдээлэл өгөх болно. Дэлгэрэнгүй мэдээллийг эндээс авах боломжтой: <http://www.vitejtevcr.cz/>

ЯГ ХЭН КУРСТ СУУСАН БАЙХ ЁСТОЙ ВЭ? Дасан зохицох-интеграцийн курсыг дүүргэх үүрэг нь гадаадын иргэд БНЧУЛсын нутаг дэвсгэрт оршин суух тухай ба зарим хуулиудын нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, хойши хууь тогтоомжуудын агуулгаар, 326/1999 оны хуулийн § 42 юмуу § 45-т заасны дагуу урт хугацаагаар оршин суух зөвшөөрөл олгогдсон гадаадын иргэн бүрт болон мөн энэ хуулийн § 66 юмуу § 67-д заасны дагуу нутаг дэвсгэрт байнга оршин суух зөвшөөрөл олгосон гадаадын иргэнд хамаарна. Тодруулбал, тус курсыг дараахь төрлийн зөвшөөрөл олгогдсон гадаадын иргэн бүр заавал дүүргэх ёстой:

- нутаг дэвсгэрт урт хугацааны оршин суух зөвшөөрөл
- оршин суух зорилго нь өөрчлөгдсөний улмаас нутаг дэвсгэрт урт хугацаагаар оршин суух зөвшөөрөл
- хүмүүнлэгийн шалтгаанаар нутаг дэвсгэрт байнга оршин суух зөвшөөрөл, ялангуяа орогнол хүсэгчийн эхнэр/нөхөр болох гадаад иргэн бөгөөд гэрлэлт орогнол хүсэгч нутаг дэвсгэрт нэвтрэхээс өмнө байсан, орогнол хүсэгчийн насанд хүрээгүй хүүхэд эсвэл түүний асрамжаас хамааралтай хүүхэд, хэрэв тэр орогнол хүсээгүй байсан бол, эсхүл урьд нь БНЧУЛсын иргэн байсан гадаадын иргэн бол;
- онцгой харгалзан үзэх шаардлагатай шалтгаанаар олгосон байнгын оршин суух зөвшөөрөл
- гадаадын иргэн оршин суух нь БНЧУЛсын ашиг сонирхолд нийцсэн бол нутаг дэвсгэрт байнга оршин суух зөвшөөрөл
- нутаг дэвсгэрт байнга оршин суух зөвшөөрөл, хэрэв БНЧУЛсын нутаг дэвсгэрт байнга оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэний хүүхэд бөгөөд эдгээр гадаадын иргэдийн нутаг дэвсгэр дээр хамт амьдрах нь өргөдөл гаргах болсон шалтгаан нь бол
- түүнийг зургаан жилийн турш тасралтгүй БНЧУЛсын нутаг дэвсгэрээс гадуур оршин суух, буюу арван хоёр сараас дээш хугацаагаар Европын холбооны нутаг дэвсгэрээс гадна оршин сууж байх үед өмнө нь олгогдсон байнга оршин суух зөвшөөрөл нь хүчингүй болгогдсоны дараа олгогдсон нутаг дэвсгэрт байнга оршин суух зөвшөөрөл,
- нутаг дэвсгэрт тасралтгүй дөрвөн жил оршин суусны дараа байнга оршин суух зөвшөөрөл, энэ нь олон улсын хамгаалал олгох тухай процедур дууссаны дараа нутаг дэвсгэрт оршин сууж буй гадаад иргэн бол.

ЭНЭХҮҮ ҮҮРЭГ НЬ ХЭНД ХАМААРАХГҮЙ ВЭ? Энэ курсыг аль хэдийн дүүргэсэн эсвэл 2021 оны 1-р сарын 1-нээс өмнө § 66 юмуу § 67-гийн заалтын дагуу урт хугацаагаар оршин суух зөвшөөрөл эсвэл байнга оршин суух зөвшөөрөл олгогдсон, тэгэхдээ тэр нь 2021.1.1-ий өдөр хүчинтэй байсан, гадаадын иргэн дасан зохицох-интеграцилагдах курст хамрагдах шаардлагагүй. Дасан зохицох-интеграцийн курсыг дүүргэх үүрэг нь БНЧУЛсад дараахь үндэслэлээр оршин сууж буй гадаадын иргэнд хамаарахгүй:

- суралцах зорилгоор урт хугацаагаар оршин суух зөвшөөрөл (оршин суух зорилгын код нь „21“, „22“, „23“ ба „30“)
- нутаг дэвсгэр хамгаалах зорилгоор урт хугацаагаар оршин суух зөвшөөрөл (оршин суух зорилгын код нь „88“)
- хөрөнгө оруулах зорилгоор урт хугацаагаар оршин суух зөвшөөрөл (оршин суух зорилгын код нь „78“)
- БНЧУЛсын Гадаад хэргийн яамнаас олгосон урт хугацаагаар оршин суух зөвшөөрөл



- компани дотроо шилжүүлсэн ажилчдын үнэмлэх (оршин суух зорилгын код нь „79“)
- Европын холбооны гишүүн өөр орны компани дотроо шилжүүлсэн ажилтны карт (оршин суух зорилгын код нь „80“)

Улмаар дасан зохицох-интеграцийн курс дүүргэх үүрэг нь оршин суух зөвшөөрөл олгох шийдвэр хууль ёсны хүчин төгөлдөр болсон өдөр 15 нас хүрээгүй юмуу мөн тухайн өдөр 61 нас хүрсэн гадаадын иргэнд хамаарахгүй. Өндөр мэргэшсэн ажилтан ба Гол болон шинжлэх ухааны боловсон хүчний засгийн газрын хөтөлбөрүүдийн хүрээнд олгогдсон ажлын ба цэнхэр үнэмлэх эзэмшигчид дасан зохицох-интеграцийн курст хамрагдах шаардлагагүй байна.

ЕВРОПЫН ХОЛБООНЫ ОРНЫ ИРГЭД, ТЭДНИЙ ГЭР БҮЛИЙН ГИШҮҮД ЯАХ ВЭ? Европын Холбооны иргэд, тэдний гэр бүлийн гишүүд ба Чех улсын иргэдийн гэр бүлийн гишүүдийн адил дасан зохицох-интеграцийн курсыг төгсгөх үүрэг хүлээхгүй.

КУРСЫГ ХЭЗЭЭ ХҮРТЭЛ ТӨГСГӨСӨН БАЙХ ЁСТОЙ ВЭ? Дасан зохицох-интеграцийн курс төгсгөх үүрэг бүхий гадаадын иргэн нь тус курсыг оршин суух зөвшөөрлийн үнэмлэх хүлээж авсан өдрөөс хойш нэг жилийн дотор, байнга оршин суух зөвшөөрөл олгох шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш нэг жилийн дотор төгсгөх ёстой.

КУРСЫГ ХЭН ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙНА ВЭ, ХААНА ЯВАГПАХ ВЭ? Дасан зохицох-интеграцийн курсыг үргэлж Гадаадын иргэдийн интеграцийг дэмжих төв удирддаг (<http://www.integracnicentra.cz>). БНЧУЛсад ийм төв арван найм байдаг бөгөөд алинд нь курст суухыг гадаад иргэн өөрөө шийднэ. Сургалтыг Гадаадын иргэдийн интеграцийг дэмжих төвтэй хамтран өөр хуулийн этгээд зохион явуулж болно. БНЧУЛсын нутаг дэвсгэрт оршин суух тухай ба зарим хуулиудын нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, хойшхи хууь тогтоомжуудын агуулгаар, 326/1999 оны хуулийн § 155а-д заасны дагуу байгуулагдсан Гадаадын иргэдийн интеграцийг дэмжих төвөөс шууд зохион байгуулагдаагүй, удирддагдаагүй курсыг үүргийн биелэлт хангасан гэж хүлээн зөвшөөрөхгүй болно.

КУРСЫГ ХЭН, ЯМАР ХЭЛЭЭР ЯВУУЛАХ ВЭ? Курсыг мэргэшсэн мэргэжлийн багш чех хэл дээр удирдаж явагдана. Дараа нь агуулгыг нь чадварлаг орчуулагч англи, араб, франц, монгол, орос, серб, испани, украин, вьетнам хэлээр орчуулна.


КУРСТ ЯАЖ БҮРТГҮҮЛЭХ ВЭ? Дасан зохицох-интеграцийн курсыг олон нийтэд зориулсан ба олон нийтэд зориулагдаагүй курсуудад хуваадаг. Олон нийтэд зориулсан курст дараахь зүйлсийг хийсэн гадаадын иргэн бүр хамрагдах боломжтой:

1. портал дээр бүртгүүлсэн <https://frs.gov.cz/kurzy>
2. 1500 кроны төлбөр төлж, төлбөрийн баримт хүлээн авсан
3. тодорхой курст нь бүртгүүлж, баталгаажуулалтыг Е-мэйлээр авна

Олон нийтэд зориулагдаагүй курсыг хуулийн этгээдийн саналыг үндэслэн, холбогдох гадаадын иргэдийн интеграцийг дэмжих төвтэй хамтран хэрэгжүүлдэг. Мөн <https://frs.gov.cz/kurzy> портал дээр бүртгүүлэх шаардлагатай – гадаадын иргэдийн төлбөр, зохион байгуулалт, сургалтад хамрагдахтай холбоотой шаардлагатай арга хэмжээг дараа нь хуулийн этгээд өөрөө хангаж өгдөг. Эдгээр курсуудыг шууд улсад төлдөггүй!

КУРС ЯМАР ҮНЭТЭЙ ВЭ, ХЭРХЭН ТӨЛБӨР ХИЙХ ВЭ? Олон нийтэд зориулагдсан дасан зохицох-интеграцийн курсын хувьд гадаад иргэний улсад төлөх төлбөрийн хэмжээ 1 500 крон байна; олон нийтэд зориулагдаагүй курсын хувьд энэ төлбөрийн хэмжээ 800 крон байна (гадаадын иргэн хэзээ ч улсад мөнгө шууд төлөхгүй, хуулийн этгээд улсад мөнгөө төлдөг). Олон нийтэд зориулсан сургалтын хувьд <https://frs.gov.cz/kurzy> портал дээр бүртгүүлсний дараа гадаадын иргэнд хувьсагчийн тэмдэг (чехээр - *variabilní symbol*) үүсгэж өгнө; дараа нь мөнгөн дүнг яамнаас гаргасан данс руу бэлэн бус шилжүүлгээр юмуу төлбөрийн хуудсаар шуудангаар шилжүүлнэ. **Төлбөр хийхэд хувьсагчийн тэмдгийг (чехээр-*variabilní symbol*) бичээгүй тохиолдол гарвал төлбөрийг хийсэнд тооцохгүй.** Олон нийтэд зориулагдаагүй курсын хувьд бүх оролцогчдын төлбөрийг тухайн курсыг захиалж, оролцогчидтой шууд холбоо барих хуулийн этгээд нэгтгэж хийдэг.

КУРС ЯВАГДАХ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ ХААНА ГАРАХ ВЭ? Курсын төрөл, болох газар ба огноо, байршил, орчуулагдах хэлний тухай мэдээллүүд олон нийтэд зориулсан сургалтанд хамрагдах тохиолдолд төлбөрийг төлсний дараа эсвэл олон нийтэд зориулагдаагүй тохиолдолд шууд хуулийн этгээд гадаадын иргэдэд нээлттэй болгоно.



КУРС ХЭР УДААН ҮРГЭЛЖЛЭХ ВЭ? Дасан зохицох-интеграцийн курс нь дөрвөн цаг үргэлжилнэ.

КУРСЫГ ТӨГСГӨХ НӨХЦӨЛ НЬ ЮУ ВЭ? Курс явагдах өдөр гадаадын иргэн нь тухайн газарт ирж, оршин суух зөвшөөрлийн үнэмлэх (ePKP)-ээ харуулж танилцуулах ба ирцийн бүртгэлийн хуудсанд ёстой ирснээ баталгаажуулж гарынхаа үсгийг зурна. Гадаадын иргэн тухайн курс явагдаж байх хугацаанд бүрэн оролцох ёстой. Курсыг ямар ч шалгалт, тестээр дуусгахгүй.

ДУУСАХАД ЮУ ОЛГОХ ВЭ? Курст хамрагдсаны хувьд гадаадын иргэнд уг сургалтыг төгсгөс гэрчилгээ олгоно.

ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭЭГҮЙ БАЙДЛЫН ЭРСДЭЛ НЬ ЮУ ВЭ? Оршин суух зөвшөөрлийн үнэмлэх хүлээн авсан өдрөөс хойш нэг жилийн хугацаанд дасан зохицох-интеграцийн дамжаанд хамрагдах үүргээ биелүүлээгүй байх нь гадаадын иргэнийг 10000 хүртэл кроны торгууль оногдуулж болох зөрчил байх болно.